



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/337

Булган сум

Нийтийн шугаман бүжгийн
“Цоглог” хамтлагийн тэмцээн, уралдаанд
оролцох зардалд дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн биеийн тамирыг дэмжих, иргэд олон нийтийг идэвхтэй хөдөлгөөнд уриалж, цэнгээнт бүжгийн ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор Дархан хотод зохион байгуулагдах ахмадуудын цэнгээнт бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох “Цоглог” хамтлагийн замын зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын “Бүх нийтийн соёлын боловсрол олгох төлөвлөгөө”-ний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010452